



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй  
дуудлагын худалдаагаар худалдах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 43,223,360.00 /дөчин гурван сая хоёр зуун хорин гурван мянга гурван зуун жаран/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашин, тракторыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ю.Ганзориг, нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанидаа төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭД

300103

Төрийн өмчийн доодлого зохицуулалтын газрын  
2020 оны 04 дугаар сарын 21-ний өдрийн  
14:27 дугаар тогтоолын хавсралт

"Архангай АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашинуудын жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, аарал	Нийт үнит /KM/ опсооюу aumrarsattaa yinjabapneces,	Балансын үнэ (төгрөг)	Хүримтлагдсан элэгдээл (төгрөг)	Сэргээх дооджийн зэрэглэлийн дооджийн төгрөг	Худалдах дооджийн (төгрөг)
1	Навара, хагас ачааны, 75-99 APX аарал № MNTCCUD40Z0006137	2010/ 2010 466000	42,426,360.00	42,426,360.00	0	500,000.00 1,000,000.00
2	Трактор, ЮМЗ-6КП, 18-17 АР, аарал № 105918	1988/ 1988 10124 цаг	800,000.00	800,000.00	0	300,000.00
	Нийт дун		43,223,360.00 /дөчин гурван сая хоёр зуун хорин гурван мянга гурван зуун жаран/ зуун жаран/	43,223,360.00 /дөчин гурван сая хоёр зуун хорин гурван мянга гурван зуун жаран/ зуун жаран/	0	0 1,300,000.00 /нэг сая гурван зүүн мянга/